

**“ЭХ, ХҮҮХЭД, НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТ**

(2018 оны жилийн эцсийн

байдлаар)

Өмнөговь аймаг

2018 оны 11 дүгээр сарын 19-ний

өдөр

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл
1	<p>“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” хөтөлбөр</p> <p>/МУ-ын Засгийн газрын 2017 оны 03 сарын 07-ны өдрийн 78 дугаар тогтоол/</p>	<p><u>Хөтөлбөрийн зорилго:</u> Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг сайжруулах нийгэм, эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлж, иргэдийн болон иргэний нийгмийн оролцоог хангах замаар эрүүл мэндийн хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээг бүх нийтэд тэгш хүргэснээр эх, хүүхдийн эндэгдлийг тогтвортой бууруулахад хөтөлбөрийн зорилго оршино.</p>
2	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын төсөв, рон нутгийн төсөв
3	Хэрэгжүүлэгч байгууллага	<p>Үндсэн хэрэгжүүлэгч байгууллагууд: Аймгийн засаг даргын тамгын газар, НБХэлтэс Эрүүл мэндийн газар Бүсийн оношилгоо эмчилгээний төв</p> <p>Хамтран хэрэгжүүлэгч байгууллагууд: Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд Сумын засаг даргын тамгын газар Төрийн болон төрийн бус байгууллагууд</p>
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд:	<p><u>Зорилт 1.</u> Эх, хүүхдийн эрүүл мэндийн асуудлыг бусад салбарын бодлогод тусгах замаар эрх зүйн орчныг сайжруулж, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, түншлэлийг дэмжсэнээр эх, хүүхдэд ээлтэй нийгэм, эдийн засгийн орчинг бүрдүүлнэ.</p> <p><u>Зорилт 2.</u> Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тэгш, хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээг бүх нийтэд хүргэнэ.</p> <p><u>Зорилт 3.</u> Нөхөн үржихүйн эрхийг хангасан гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээний хүртээмж, хэрэглээг нэмэгдүүлэх замаар хүсээгүй жирэмслэлт болон үр хөндөлтийг бууруулна.</p> <p><u>Зорилт 4.</u> Хүн амд жендэрийн мэдрэмжтэй эрүүл мэндийн боловсрол олгон эрүүл зан үйлийг төлөвшүүлэн эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг хамгаалахад гэр бүлийн гишүүд, иргэдийн оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлнэ.</p> <p><u>Зорилт 5.</u> Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж,</p>

		үйлчилгээний бүртгэл, мэдээлэл, тандалт, судалгаа, хяналт-шинжилгээ, үнэлгээг сайжруулна.			
5	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал)			
		Үүнд:	Төсөв (2018 он)	Гүйцэтгэл	Хувь
		Багц /сая төгрөг/	50.000.000	??????	??????

6	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Ажлуудын биелэлт
7	<p>1-р зорилтын хүрээнд:</p> <p>Хүрэх үр дүн: Эх, хүүхдийн эрүүл мэндийн эрх зүйн орчин боловсронгуй болж, салбар хоорондын хамтын ажиллагаа, түншлэл сайжирч, санхүүгийн нөөц нэмэгдсэнээр эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндэд ээлтэй орчин бүрдэнэ.</p>	<p>“Эх хүүхдийн эрүүл мэнд” аймгийн дэд хөтөлбөрт орон нутгаас 2018 онд 50 сая төгрөгийг ИТХ-аар батлуулан, 87,3% хэрэгжүүлэн ажилласан.</p> <p>Аймгийн хэмжээнд 2018 оныг “Эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарласан Засаг даргын захирамж гарч, 5,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар эрүүл мэндийн байгууллагын барилга, техник хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, хүний нөөцийг бэхжүүлэх, үзлэг оношилгоо зэрэгт зарцуулагдаж байна.</p> <p>Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, сум, баг, өрх шалгаруулах болзолт уралдааны удирдамж гарган, батлуулж, тодорхой давтамжтай 2 удаагийн нөлөөллийн уулзалт зохион байгуулсан. Засаг даргын албан даалгавар, болзолт уралдааныг идэвхжүүлэх зорилгоор Эрүүл мэндийг дэмжигч байгууллага тугийг 15 суманд төрийн нийт байгууллагад аялуулж 98 хувьтай хэрэгжиж байна. 5 удаагийн олон нийтийн арга хэмжээ дээр болзолт уралдааныг танилцуулж нийт 300 гаруй иргэн 40 гаруй албан байгууллагад танилцуулга хийгдсэн.</p> <p>Сумдын Засаг дарга нарт нөлөөллийн уулзалтыг 2 удаа зохион байгуулж, сайн жишээ, эмнэлгийн тусламжийн чанарын үзүүлтэд эхийн тусламжийн нөлөөлөх байдлыг таниулсан.</p> <p>Сумаас аймаг руу солилцох хуудсаар шилжүүлсэн 584 жирэмсэн эмэгтэйг эмнэлгийн зардлаар хүргэсэн.</p> <p>Сумын ЗД-ын дэмжлэг авсан байдал: Сэврэй сумын ЭМТөвд ПРИУС-20 маркын автомашин, Цогцэций сумын СДЭ-т 30 сая төгрөгийн төрөх эмэгтэйчүүдийн тасгийн тоног төхөөрөмж, Баян-Овоо сумын ЭМТ-д 4 сая төгрөгийн эхийн амрах байрны тохижилтод тус тус сумын Засаг дарга нар нь дэмжлэг үзүүлсэн байна.</p> <p>Жирэмсний хяналт, өсвөр үед ээлтэй үйлчилгээг анхан шатанд оновчтой болгох нь зөвлөлдөх уулзалтыг 2018 оны 6 сард зохион байгуулж, 15 сумын Засаг дарга, ЭМГ-ын мэргэжилтнүүд, БОЭТ, 18 анхан шатны эмнэлгийн дарга, эх баригч нар нийт 90 хүн оролцсон.</p>

Дутуу нярайн тусламж үйлчилгээнд сурфактант эмчилгээг 2017 оны сүүлээр нэвтрүүлэн, 2018 онд 10 дутуу нярайд хэрэглэж, 80% нь амжилттай эмчлэгдсэн.

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 250 сая төгрөгний өртөгтэй эмэгтэйчүүдийн мэс заслын дурангийн аппарат нийлүүлэгдсэн. Мөн Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн 50 сая төгрөгний санхүүжилтээр 4 төрлийн 23 ширхэг эх, хүүхдийн тусламж үйлчилгээний тоног төхөөрөмжөөр хангасан.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 20сая төгрөгөөр Ханбогд, СДЭ, Ноён СДЭ, Гурвантэс сумын эрүүл мэндийн төвийг Эрүүл мэндийн газартай холбох телемедициний тоног төхөөрөмжийг шинээр нэвтрүүлсэн. Дээрх сумдын эмч мэргэжилтнүүдэд зайлшгүй сургалт явуулж, зөвлөгөө өгөх бүрэн боломж нээгдсэн. Одоогоор 1 удаагийн сургалт зохион байгуулаад байна.

Эмч, мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх зорилгоор 54 эмч мэргэжилтэнг үндсэн мэргэжил олгох болон төрөлжсөн мэргэжил олгох урт болон богино хугацааны сургалтад орон нутгийн санхүүжилтээр сургаж мэргэшүүлж байна. Үүнээс 12 эмч, мэргэжилтэнг Тайвань Солонгос улсад орон нутгийн зардлаар туршлага судлуулж мэргэшүүлсэн. Тайвань улсад 1 мэргэжилтэнг Зөгийн үүр хөтөлбөрийн хүрээнд магистрын зэрэг олгох сургалтад хамруулж байна. Дотоодод урт болон богино хугацааны сургалтад 42 эмч мэргэжилтэн хамрагдахад орон нутгаас 36.7 сая төгрөгний дэмжлэг үзүүлсэн. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тусламж үйлчилгээг тасралтгүй чанартай хүргэх үүднээс нэн шаардлагатай байсан хүүхэд, шүд, чихэр, хамар хоолойн нарийн мэргэжлийн эмч нарыг орон нутагт татан авч ажиллуулан, тэдэнд орон нутгаас 21 сая төгрөгний орон байрны түрээсний дэмжлэг үзүүлж, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлсэн.

БОЭТ-ийн эх барих эмэгтэйчүүд, хүүхдийн эмчийн хангалтыг нэмэгдүүлэн 2 хүүхдийн эмчийг “Хүүхдийн бөөр судлал”, “Нярайн судлал”-аар нарийн мэргэжил эзэмшүүлэн ажиллаж байна. Хүрмэл сумын ЭМТ-д нярайн нарийн мэргэжлийн эмч сурган ажиллуулаад байна.

15 сумын 17 эх баригчийг БОЭТ-ийн төрөх эмэгтэйчүүдийн тасагт 14 хоногийн ажлын байрны дагалдан сургалтад хуваарь гарган 88% хамруулсан. Сумдуудийн жирэмсний хяналт хариуцсан 5 эмч нарыг БОЭТ-д чанд авиан шинжилгээний баримжаа олгох сургалтад хамруулсан.

АШУУИС, Дорноговь, Дархан, Сувилахуйн сургууль салбар сургуулиудад ажиллаж 300 орчим төгсөгчидтэй уулзаж 30 орчим шинэ төгсөгчидийг орон нутагтаа ажиллуулах урилга гардуулж, нийгмийн дэмжлэгийг орон нутгийн удирдлагуудад тавьж

2-р зорилтын хүрээнд:

Хүрэх үр дүн: Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангаж, оношилгоо, эмчилгээний дэвшилтэт аргыг нэвтрүүлж, хүний нөөцийг чадавхжуулснаар эх, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар сайжирна.

	<p>шийдвэрлүүлсэн.</p> <p>Жирэмсний хяналт, гэр бүл төлөвлөлт ба эх барихын яаралтай тусламж сэдэвт 16 цагийн багтаамжтай сургалтыг 30 эх баригчийг хамруулан, 2018 оны 6-р сарын 25-26 нд зохион байгуулсан. Сургалтыг АШУУИС, ЭХЭМТ, НҮБ-ын ХАС-ын 6 багш багаар удирдан явуулсан. Сургалтын өмнөх сорил 68% сургалтын дараах сорил 93% ахиц 25%. Сургалтын өмнө ур чадварыг 2 минутаар үнэлж, сургалтын дараа үнэлэхэд ур чадвар 38% нэмэгдсэн.</p>
<p>3-р зорилтын хүрээнд:</p> <p>Хүрэх үр дүн: Нөхөн үржихүйн эрхийг хангасан гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээний хүртээмж, хэрэглээ нэмэгдэж, хүсээгүй жирэмслэлт болон үр хөндөлт буурна.</p>	<p>-ЖЗӨК ийн сургалтын танхимыг 2016 оны 9 сараас Манлайлагч эмэгтэйчүүд клубээс тохижуулан, тогтмол ажиллуулж хэвшсэн ба жирэмсний дасгал хичээлүүдэд давхардсан тоогоор 3000 орчим эхчүүд хамрагдсан байна. Япон улсад мэргэжил дээшлүүлсэн эх баригч Японы Их сургуулийн багш Сүзүки Эмикогийн боловсруулсан жирэмсний дасгалыг үзлэгийн өмнө өглөө бүр хийж, 9.30 цагаас ЭМС-ын 338-р тушаалын дагуу эрүүл мэндийн боловсрол олгох сургалтаа тогтмол явуулдаг.</p> <p>Жирэмсний таргалалтаас үүдэлтэй, жирэмсний болон төрөлтийн хүндрэлүүд гарч байгаатай холбоотойгоор ЭМГазар, БОЭТ-тэй 3 сум дундын эмнэлэг дээр 50 жирэмсэн эмэгтэйд дасгал хөдөлгөөн, хичээл зааж, 18 баригчийг дагалдуулан, сургагч багшаар бэлтгэсэн.</p> <p>-НҮБ-ийн ХАС-тай хамтран ГБТ, ЖСА-ийн сургагч багшаар 25 эх баригчийг бэлтгэн, нийт нөхөн үржихүйн насны 8976 эмэгтэйд зөвлөгөө өгсөн.</p> <p>-БОЭТ дээр Бэлгийн болон НҮЭМ-ийн цогц кабинет байгуулахаар төлөвлөн, барилгын засварын ажил 90%-тай байна.</p> <p>-Хилийн цэргийн 0131-р анги, БОЭТөвтэй хамтран, Дотор, хүүхэд, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, БЗДХ илрүүлэх үзлэгт хилийн 8 заставын 286 хүнийг хамруулж, зөвлөгөө өгсөн ба хилийн цэргийн эмч мэдээллийн сандаа бүртгэн авч, эрүүлжүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.</p> <p>-Аймгийн засаг даргын санаачлагаар өөр аймгийн нутагт отроор яваа малчдыг эргэх, эмнэлгийн тусламж үйлчилгээ хүргэх ажлыг сумдын эмнэлэг, хувийн хэвшлийн эмнэлэгтэй хамтран зохион байгуулсан бөгөөд Дундговь, Өвөрхангай, Дорноговь аймгуудын 7 сумын 17 айлын хүүхэд, эмэгтэйчүүд, том хүн нийлээд 48 хүнд үзлэг хийж, зөвлөгөө өгсөн. Мөн анхны тусламжийн эмийн сангийн багцыг айл бүрт бэлэглэсэн.</p> <p>-АЗДТГазар, БОЭТөвтэй хамтран Явуулын нэг цэгийн үйлчилгээг малчдад хүргэх арга хэмжээ зохион байгуулж, Булган, Ханхонгор, Баяндалай сумдуудын малчин иргэдэд багийн төв дээр нь үзлэг зохион байгуулсан. Нийт 133 хүнд үзлэг хийж, зөвлөгөө өгсөн. Хүүхдийн үзлэг 10%-ийг эзэлж байна. Өвчлөлтэй гарсан иргэдийг сумын эмчийн хяналтад шилжүүлсэн.</p> <p>-Даланзадгад, Ханбогд, Цогтцэций сумын өсвар үеийн клиникт 680 охидыг үзлэг, оношилгоонд хамруулж, зөвлөгөө өгсөн. 280 охидоос МАЗОК-ын шинжилгээ авч, эмчилгээ заасан.</p> <p>-УИХ-ын гишүүн Н.Амарзаяагийн санаачлагаар "Амьдрахад таатай говь нутаг-2018" арга хэмжээ гурав дахь жилдээ "Төрийн үйлчилгээг-Багт" уриатайгаар 21 хүний бүрэлдэхүүнтэй баг 8 сумдын 30 багт</p>

		<p>ажиллаж, 2500 гаруй хүүхэд, давхардсан тоогоор 9000 орчим иргэдэд 4 мэргэжлийн нарийн мэргэжлийн тусламжид хамруулан, эмчилгээ зааж эрүүлжүүлэлтийг эхлүүлсэн.</p> <p>-</p>
	<p>4-р зорилтын хүрээнд:</p> <p>Хүрэх үр дүн: Эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих асуудалд гэр бүлийн гишүүд, иргэний оролцоо, үүрэг хариуцлага нэмэгдэнэ.</p>	<p>Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжих аян, өдөрлөгийн арга хэмжээг 15 сумыг хамруулан, 3 удаа зохион байгуулсан. Нэгдсэн өдөрлөгт оролцсон 1550 гаруй иргэдэд, 4 төрлийн 2550 мэдээлэл сурталчилгааны материал хүргэсэн. Аяны хүрээнд сум бүр СЗДТГазартай хамтран, дэмжлэг туслалцаа авч, өдөрлөгийн арга хэмжээг өргөн хүрээнд зохион байгуулж, “Сайн аав ээж”-ийн сургалт, мэргэжлийн эмчийн үзлэг, зөвлөгөө, мэдээлэл сургалт сартчилгаа хийгдсэн. 5000 орчим иргэд аянд нэгдэж, 158 аав, ээжийг сургалтад хамруулан, 20 “Сайн аав ээж”-ийг шагнаж урамшуулсан.</p> <p>Мөн аяны хүрээнд 3 сум дундын эмнэлэг дээр өртөөчилсөн сургалтзохион байгуулж, 60 орчим иргэдийг хамруулан. НҮЭМ, гэр бүл төлөвлөлт, бэлгийн замаар дамжих халдвар, ХДХВ, , бэлгэвчийн хэрэглээ, хүүхдийн асаргаа сэдвүүдээр мэдлэг олгосон.</p> <p>Эрүүл мэндийн газар 2, өсвөр үеийн ээлтэй клиник 3, Сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төв 3 Нөхөн үржихүйн эрүүл мэндийн сургалтын багцаар хангагдаж, мэдээлэл сургалт суртчилгаа явуулах боломжоор бүрэн хангагдсан.</p> <p>Хүүхдийн зуны сувилалд 197 хүүхдийг хамруулан, нэг хүүхдийг 7-14 хоногийн хугацаатай сувилалд хамрууллаа. Сувиллаар өдөрт 2 удаа витаминжуулан, өдөрт 2-3 удаа хоолоор сувилж , айраг, шар сүү, хар цай, давс, хужраар шавшлага, бигнүүр хийж, элсэн дээр наран шарлага хийсэн. Эрдэсжүүлсэн усанд оруулж тосон массаж хийсэн. Өдөр бүр сүү, тараг цагаан идээгээр үйлчилсэн. Тусламж үйлчилгээг эмч, сувилагч нар хүргэж, эцэг, эхчүүдэд хүүхдээ асран сувилах, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх арга барил эзэмшүүлсэн.</p>

	<p>5-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээрх судалгаа, тандалт, статистик бүртгэл, мэдээлэл чанаржиж, нотолгоонд суурилсан бодлого шийдвэр гаргах боломж бүрдэнэ.</p>	<p>-Даланзадгадын 3 ӨЭМТ –үүдэд эх, хүүхдийн тусламж үйлчилгээ, халдвар хяналт, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, сувилахуйн тусламж үйлчилгээний чиглэлээр ЭМГ-ын ЭТҮХ-ээс хяналт үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлсэн. БОЭТ-ийн бүх тасаг нэгжээр 2 удаа зөвлөн туслах, хяналт үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилт 80% байсан. -Жирэмсэн эмэгтэйчүүдийн эрт үеийн хяналтыг сайжруулах зорилгоор эмнэлгүүдийн 50%-д нь ажлын байран дахь хяналт үнэлгээ хийж, 100% дотоодын үнэлгээ хийлгэж, дүгнэлт, зөвлөмжөөр хангаж, 3 удаа 21 эмнэлэгт зөвлөмж өгч, хэрэгжилтийг дүгнэхэд 78% байна.</p> <p>-Хагас жилийн байдлаар хүүхдийн эндэгдэл хамгийн өндөр бүртгэгдсэн Баян-Овоо суманд 10 сард ЭМГ-ын даргаар ахлуулсан зөвлөн туслах баг хяналт үнэлгээ хийж, газар дээр нь зөвлөмж өгсөн.</p> <p>-Эх барихын арга зүйч ажиллуулж төрөх тохиолдол бүрт НЭҮНШТУ-г нэвтрүүлэн, хяналт үнэлгээг тогтмолжуулж, жирэмсний дасгал, сургалтын чанарыг сайжруулсан.</p> <p>-Эх яагаад эндэв, хүүхэд яагаад эндэв зөвлөмжийн дагуу АЗД-ын захирамж, ЭМГ-ын даргын тушаал гаргуулж, тушаалын дагуу хяналтын хуудсаар дотоодын үнэлгээ хийж, хэлэлцүүлэг зохион байгуулсан. Үнэлгээ дунджаар 75% байсан ба 18 анхан шатны эмнэлэг үйл ажиллагаандаа дүгнэлт хийж, ур чадвараа сайжруулах, эх хүүхдийн тусламжийг сайжруулахад эн тэргүүнд хэрэгжүүлэх ажлаа тодорхойлсон.</p> <p>-Өртөмхий бүлгийн жирэмсэн эмэгтэйг давхар хяналтын тогтолцоогоор хянах мэдээллийг сар бүр анхан шатны эмнэлгүүдээс авч, эх барих эмэгтэйчүүдийн ерөнхий мэргэжилтэн, зөвлөх эмч, ЭМГ-ын мэргэжилтнүүд үнэлгээ дүгнэлт өгч эмч, мэргэжилтнүүдэд зөвлөгөө өгч, зохион байгуулалтын арга хэмжээ авч, эргэх холбоотой ажилладаг болсон. Давхар хяналтад сард дунджаар 109 жирэмсэн эх орсоноос 95%-ийг эх барих эмэгтэйчүүдийн эмчийн хяналтад авч ажиллаж чадсан. Зөвлөх эмч нарт бусад эмнэлэгт зөвлөмж өгөх цаг зав муутайгаас хамтын ажиллагаанд зарим нэг шийдвэрлэх асуудлууд гарсаар байсан.</p>
8	<p>Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)</p>	<p>Ололт: Аймгийн ИТХТ-ийн 2016 оны 53-р тогтоолоор “Эх хүүхдийн эрүүл мэнд” хөтөлбөрт жил бүр орон нутгаас төсөв батлуулан, амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна. 2018 оны хөтөлбөрийн хэрэгжилт 87.3%.</p> <p>Дутагдалтай тал: Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс санхүүжилт тавигддаггүй нь өргөн хүрээний үйл ажиллагаа явуулах боломж муу, ялангуяа нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээг улс даяар сайжруулах үүднээс ЖСАХ-ийн хэрэглээг хангах нь хамгаас чухал байна.</p>
9	<p>Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ</p>	<p>САЙН</p>
10	<p>Хөтөлбөрийн Биелэлт</p>	<p>Зорилты Зорилт 1 Зорилт 2 Зорилт 3 Зорилт 4 Зорилт 5</p>

	хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт		Н тоо					
		Дундаж 90%	5	90%	95%	90%	85%	90%
11	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ						
		90%						

Хэрэгжилт гаргасан..... /Ж.Отгобайгал/
Хянасан /Б.Амгалан/